



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 115

Баянхутаг сум

**Эзэмшил газрын талбай хэмжээ,  
байршил өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 20.1.43 дахь хэсэг, Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.57 -д тусгагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжсэнтэй холбогдуулан хавсралтанд дурьдсан 1 хоршоонд 30000 м2 газрыг мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2. Захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2024 оны А/94 тоот захирамжийн холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгож гэрээг байгуулан, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамлын түр орлон гүйцэтгэгч /Т.Наранбаяр/-т, гэрээнд заасан зориулалт, нөхцлийг хангаж ажиллан, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч малчдын хоршоонд үүрэг болгосугай

ДАРГА



Б.АМГАЛАНБАТ

Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар  
сарын 12 өдрийн 123 тоот захирамжийн  
..... тоот хавсралт



| № | Газар эзэмшигчийн |                   | Өмнөх захирамжийн |        |                   |                          | Өмнөх газрын |          | Одоо        |                                       |
|---|-------------------|-------------------|-------------------|--------|-------------------|--------------------------|--------------|----------|-------------|---------------------------------------|
|   | Оноосон нэр       | Регистрийн дугаар | Огноо             | Дугаар | Хавсралтын дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Хэмжээ /м2/  | Хаяг     | Хэмжээ /м2/ | Хаяг                                  |
| 1 | Голын эрзэн       | 4208455           | 2024/10/01        | A/94   | 1                 | 6                        | 50000        | Хаялагат | 30000       | Хаялагат петровис колонкын баруун урд |
|   |                   |                   |                   |        |                   |                          | 50000        |          | 30000       |                                       |